



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/2021

Улаанбаатар хот

「Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах
ажиллагааны албаны эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1,600,000 (нэг сая зургаан зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (Б.Оргилболд)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 1,600,000 (нэг сая зургаан зуун мянга) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 20,000 (хорин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 6,000 (зургаан мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (Б.Оргилболд)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000771

Нийслэлийн Өмчийн ажиллалт, удирдлагын газрын даргын 2021 оны дугаар сарын өдрийн дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Эвдрэл гэмтэл	Байгууллагын үнийн санал	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Зөөврийн компьютер	7	ш	1	1,600,000	1,600,000	1,600,000	-	Хард шатсан, дэлгэц гэмтсэн	20,000	20,000
Нийт данснаас хасах машин тоног төхөөрөмжийн дүн											
Үүнээс: Худалдах хөрөнгө											
Устгах хөрөнгө											
Худалдсанаас олох орлого											
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/											
										20,000	20,000
										6,000	6,000